

“Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын
Хавсралт 4-а

АЛБАН МЭДЭГДЭЛ
/Өмнөговь аймгийн бонд/

Огноо: 2025/12/22

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах Өмнөговь аймгийн үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол Улсын Засгийн газар /орон нутгийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Бонд гаргагч аймгийн нэр:

Өмнөговь аймаг

1.2 Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар:

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8/23 тоот “Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” шийдвэр

1.3 Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар:

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 08-р сарын 13-ны өдрийн 43 тоот “Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” тогтоол

1.4 Бондын нэр:

Өмнөговь бонд

1.5 Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/:

Зэрэглэл тогтоолгоогүй



1.6 Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр:

Зэрэглэл тогтоолгоогүй

1.7 Тоо ширхэг:

5,000,000 (таван сая) ширхэг хүртэл

1.8 Нэрлэсэн үнэ:

100,000 (зуун мянга) төгрөг

1.9 Хугацаа:

24 сар хүртэл (Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр транч бүрд тогтооно)

1.10 Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:

Жилийн хүү: 16.0 хувь хүртэл (Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр транч бүрд тогтооно)
Хүүгийн төрөл: Тогтмол

1.11 Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:

Үндсэн төлбөр хугацааны эцэст, хүүгийн төлөлт хагас жил тутамд

1.12 Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/

Энгийн тогтмол хүүтэй бондын хөтөлбөр (хугацаанаас өмнө эргүүлэн худалдах, худалдан авах болон хөрвөх нөхцөлтгүй)

1.13. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:

500,000,000,000 (таван зуун тэрбум) төгрөг



1.14. Тодорхой үе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол дэлгэрэнгүй мэдээлэл:



2025-01-05

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 08-р сарын 13-ны өдрийн 43 тоот “Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын хавсралт 1-д заасан дараах хуваарийн дагуу энэхүү үнэт цаасны хөтөлбөрийг хэсэгчлэн гаргаж арилжаална. Үүнд:

- 2026 онд: 150,000,000,000 төгрөг;
- 2027 онд: 300,000,000,000 төгрөг;
- 2028 онд: 50,000,000,000 төгрөг

Дээрх хуваарийн дагуу хэсэгчлэн гаргахад бондын хугацаа, хүү зэрэг тодорхой нөхцөлүүдийг Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тухай бүр тогтооно.

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн жилийн төсөвт тусгасан шийдвэр болон тус шийдвэрийг үндэслэсэн Өмнөговь аймгийн Засаг Даргын захирамжийн дагуу транч тус бүрийн анхдагч зах зээлийн арилжааг явуулна.

1.15. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:

Бондын хөтөлбөрийг Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 4.3.1-д заасан хугацаанд багтаан анхдагч зах зээлд арилжаалах бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 08-р сарын 13-ны өдрийн 43 тоот “Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын хавсралт 1-д заасан хуваарийн дагуу хэсэгчлэн санал болгоно. Бондын анхны нийлүүлэлтийг Хороонд бүртгүүлснээс хойш 6 сарын дотор хийнэ. Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.5-д заасны дагуу бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт тусгагдсан тухай шийдвэр болон анхдагч зах зээлийн арилжааг явуулах тухай Өмнөговь аймгийн Засаг Даргын захирамжийн хамт уг ажиллагааг эхлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.



1.16. Үнэт цаасаар гэрчлэгдэх хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг:

Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг:

- Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.
- Анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээлд чөлөөтэй худалдах эрхтэй.
- Бондтой холбоотой санал, гомдол аливаа хүсэлтийг Андеррайтерт мэдэгдэх эрхтэй.
- Бонд эзэмшигч нь бондыг анхдагч болон хоёрдогч зах зээлээс худалдан авах, хоёрдогч зах зээлд худалдахтай холбоотой арилжааны шимтгэл, хураамж болон бусад зардлыг өөрөө хариуцна.
- Бонд эзэмшигч нь бондын хүүгийн орлого болон арилжааны ашгаас төлөх татварын зардлыг өөрөө бүрэн хариуцна.
- Хоёрдогч зах зээлийн арилжаанаас бий болсон аливаа алдагдалд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер компани хариуцлага хүлээхгүй.
- Бондыг худалдан авахад төлж буй мөнгөн хөрөнгө, түүний эх үүсвэр нь хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд “Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх хууль”-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
- Бондын үндсэн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, албан мэдэгдэл болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
- Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

1.17 Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай 2025 оны 08-р сарын 20-ны өдөр “Даланзадгадын 50МВт-ын дулааны цахилгаан станцын эх үүсвэр татах зөвлөх үйлчилгээний ажил”-ын гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээний ажлын даалгаварт зааснаар Монголын Хөрөнгийн Бирж, Хорооны бүртгэлийн журам, Аймаг нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам зэрэг холбогдох хууль, журмын шаардлагыг хангах, Үнэт цаасны танилцуулга /маягт, мэдэгдэл/ бэлтгэх, Үнэт цаасны бүртгэлтэй холбоотой мэдээллийг захиалагчийн зөвшөөрөлтэйгөөр бусад этгээдүүдэд танилцуулах, бондын санхүүжилтийг татан төвлөрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн тус гэрээнд дараах эрх, үүргүүдийг тусгасан байна.

Гүйцэтгэгч /Андеррайтер/-ийн эрх, үүрэг:

- Гүйцэтгэгч нь үйлчилгээг захиалагчийн баталсан ажлын даалгавар, тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь ажлын явцын мэдээлэл, ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээллийг захиалагчид өгнө.

2026.01.08

БҮРГЭЭ



№ 01

2026-01-05

- Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хуваарь болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- Хөтөлбөр (төлөвлөгөө)-г өөрчлөлт оруулсан тохиолдолд захиалагч болон захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- Гүйцэтгэгч нь захиалагч, түүнээс эрх олгосон этгээдийг ажлын талбайд нэвтрүүлэх, ажлын явцтай танилцуулах, шаардлагатай мэдээллээр хангана.
- Гүйцэтгэгч нь захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ байгуулах маягтад заана.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн дадлага, туршлага бүхий этгээд байна.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн, зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол захиалагчид учирсан хохирол, гэрээний алдангийг төлнө.
- Хууль тогтоомжид заасан бусад

Захиалагч /Үнэт цаас гаргагч/-ийн эрх, үүрэг:

- Захиалагч нь ажлын үр дүнг тухай бүр хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
- Захиалагч нь хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт, бичиг зөвшөөрлийг зохих ёсоор гаргаж өгнө.
- Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
- Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих, төлөөлөгчийг Захиалагч томилно.
- Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа өгөгдөл, шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгчид гаргаж өгнө.
- Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн, зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол өөрт учирсан хохирол, гэрээний алдангийг гаргуулахаар шаардана.
- Хууль тогтоомжид заасан бусад



1.18 Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр:

- Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох;
- Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох /Андеррайтертай гэрээ байгуулсан бол. Дараах аргын аль нэгийг сонгоно уу/
 - Захиалгын бүртгэлийн арга
 - Тогтсон үнийн арга
 - Бонд гаргагч дангаар олон нийтэд санал болгох

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1 Өмнөговь аймаг нь олон нийтэд санал болгон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

2.1.1 Үйл ажиллагаа-1

2.1.1.1 Нэр: Даланзадгадын 50МВт-ын дулааны цахилгаан станц барих

2.1.1.2 Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх хувь [%]: 100%

2.1.1.3 Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: Бүтээн байгуулалтын үе шат 2026 онд эхэлж, 2028 онд бүрэн ашиглалтад орно.

2.1.1.4 Хэрэгжүүлэгч этгээд:

- Орон нутаг;
- Хувийн хэвшил;
- Төр, хувийн хэвшлийн түншлэл.

2.1.1.5 Бэлэн байдлын үнэлгээ:

- Зураг, төсөл;
- Техник, эдийн засгийн үнэлгээ;
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ;
- Тусган гүйцэтгэгч;
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт;
- Шаардлагатай бусад

2.1.1.6 Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:



Алсын хараа 2050-д нийцсэн байдал:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.34-д “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно” гэж заасан нь Үнэт цаас гаргагчийн бондоор татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтад нийцэж байна.

Шинэ сэргэлтийн бодлогод нийцсэн байдал:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2.1-д заасан “Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ” гэж заасан нь нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4.6-д “Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина” гэж тусгагдсан.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байдал:

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 1.6.1.3-д “Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж заасан бөгөөд төсвийн нийт өртөг 473 тэрбум төгрөг, тухай жилд шаардлагатай санхүүжилтийн өртөг 142 тэрбум төгрөг байхаар тусгажээ.

Улсын төсөвт тусгагдсан байдал:

Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.3-д аймаг, нийслэлийн гаргах үнэт цаасны дээд хэмжээг 425 тэрбум төгрөг байхаар тусгасан бөгөөд тус хуулийн танилцуулгын 3.4 дэх хэсэгт “Даланзадгадад 50 МВт-ын дулааны цахилгаан станц барих төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд төслийн бүтээн байгуулалтын үе шат 2026 онд эхэлж, 2028 онд бүрэн ашиглалтад орно. Төслийн нийт хөрөнгө оруулалт 130.0 сая ам.доллар бөгөөд аймгийн үнэт цаасаар 100 хувь санхүүжүүлнэ.” гэж тусгасан байна.

Орон нутгийн бодлого, чиглэлд нийцэж буй байдал:

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/08 тоот шийдвэрээр батлагдсан Өмнөговь аймгийн Засаг Даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн 1.1.3-д Даланзадгад суманд 50 МВт-ын хүчин чадалтай дулаан, цахилгааны хосолсон үйлдвэрлэлийн станц байгуулах говийн бүсийг зорилтыг хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

2026.01.08

MINNESOTA STOCK EXCHANGE

2028-01-05

БҮРТГЭВ-03

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө:

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүд хурдацтай нэмэгдэж байгаатай холбоотой 2023 онд цахилгааны хэрэглээ 59.2 сая КВт.ц байсан бол 2033 онд 105.8 сая КВт.ц-д хүрэхээр тооцоологдож байна. Гэвч одоогийн ашиглаж буй 9МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц нь ашиглалтын хугацаа дуусаж хуучирсан бөгөөд одоогийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй байна. Тус станц нь ердөө 30.6 сая КВт.ц хэрэглээг даах чадвартай бөгөөд үлдсэн хэрэглээг төвийн эрчим хүчний системээр хангаж байгаа нь эрчим хүчний найдвартай бус, хараат байдлыг болгоод байна.

Иймд бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгөөр 50 МВт-ын цахилгаан станцыг байгуулснаар Даланзадгад сумын эрчим хүчний хэрэглээг хангаад зогсохгүй бүсийн хэмжээнд эрчим хүчний ачааллыг бууруулах, бие даасан хангамж бий болгох, уул уурхайн томоохон төсөл, аялал жуулчлал, орон нутгийн хөгжилд суурь дэд бүтцийн дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм. Мөн тус төслийг хэрэгжүүлснээр орон нутагт 150-200 хүний байнгын ажлын байр бий болж, орон нутгийн хэрэглэгчид хямд өртөгтэй, тасралтгүй дулаан, цахилгаанаар хангагдана. Мөн аймгийн эдийн засагт шууд болон шууд бус байдлаар татвар, хураамж, дотоод хэрэглээний өсөлт авчрах эерэг үр нөлөөтэй байна.

Үүсэж болох эрсдэл:

Цахилгаан станцыг барих төсөл нь 2026 онд эхэлж, 2028 онд бүрэн ашиглалтад орох бөгөөд бэлтгэл ажил 6 сар, барилга угсралт 24 сар, туршилт тохируулга 6 сар байхаар төлөвлөсөн. Төслийн нийт төсөвт өртөг 130 сая ам.доллар бөгөөд хэрэгжиж байх хугацаанд макро эдийн засгийн орчин, БНХАУ-ын бодлого зэргээс хамааран тоног төхөөрөмжүүд, барилгын материалын үнэ өсөх, цалингийн зардал нэмэгдэх зэргээр нийт төслийн санхүүжилт өсөж, улмаар орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсгэх эрсдэлтэй.

2.2. Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай

Өмнөговь Аймгийн Засаг Даргын Тамгын Газар болон түүний төслийн нэгж нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.



2.3. Хориглох үйл ажиллагааны жагсаалт

Өмнөговь аймаг нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, журамд зааснаас бусад үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

2.4. Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт зарцуулалтыг Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс тайлагнах бөгөөд санхүү, төрийн сангийн хэлтэс нь бондын зарцуулалтын ил, тод байдлыг хангаж ажиллана.

2.5. Шаардлагатай бусад мэдээлэл

3. Тайлагнал

3.1 Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж

Хорооны “Өрийн хэрэгсэл бүртгэлийн журам”-ын 8.10-д заасны дагуу олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон эргэн төлөлтийн талаарх мэдээллийг улирал тутамд дараа сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ. Мөн энэхүү журмын 8.7.1-д заасны дагуу үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон бол Хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус мэдээлэл хүргүүлж, нийтэд мэдэгдэнэ.

Хорооны “Өрийн хэрэгсэл бүртгэлийн журам”-ын 4.5-д заасны дагуу бондын хөтөлбөрөөс анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд тус мэдэгдэлд төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээллийг хавсаргана.

Дээрх журмын 7.2.11-д заасны дагуу бондыг анхдагч зах зээлд санал болгон худалдах үйл ажиллагаа амжилттай болсон тухай мэдэгдлийг Хороо ирүүлснээс ажлын 3 өдрийн дотор Өмнөговь аймгийн Засаг Дарга нь бондыг анхдагч зах зээлд санал болгосон тухай болон эргэн төлөлтийн хуваарийн талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2026.01.08

БҮРТГЭВ

№ 01

MONSOLIAN STOCK EXCHANGE

2026-01-05

3.2 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд

Засгийн Газар дахь хяналтын тухай хууль болон 2025 оны 01-р сарын 29-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 43 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт шинжилгээ хийх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэлгээ хийх журам”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу үйл ажиллагааны явцыг үнэлж, хэмжинэ.

Хорооны “Өрийн хэрэгсэл бүртгэлийн журам”-ын 4.5-д заасны дагуу бондын хөтөлбөрөөс анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд тус мэдэгдэлд төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээллийг хавсаргана.

3.3 Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

Өмнөговь аймгийн Засаг, даргын Тамгын газар
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс
Утас: 70533433
Санхүү, төрийн сангийн хэлтэс
Утас: 70533632

2026.01.08
БҮРТГЭВ
№ 01

БАТАЛГААЖУУЛСАН:

MONSOLIAN STOCK EXCHANGE
028-01-05
БҮРТГЭВ-03

Овог, нэр: Насанбуян овогтой Энхбат
Албан тушаал: Өмнөговь аймгийн Засаг дарга

Гарын үсэг:.....
(Тамга/тэмдэг)

Овог, нэр: Амарсайхан овогтой Өлзийдэлгэр
Албан тушаал: “Мандал Капитал Маркетс
ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....
(Тамга/тэмдэг)

Овог, нэр: Баярхүү овогтой Очгэрэл
Албан тушаал: Өмнөговь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гарын үсэг:.....
(Тамга/тэмдэг)

[Хорооны тусгай тэмдэглэл]